208

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 01 79, Факс: (976-11) 32 22 15
Цахим шуудан: info@mtd.gov.mn
Цахим хуудас: www.mtd.gov.mn

2025.01.06 № 01/49
2024.11.24 37
-ны №

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ГАНХУЯГ ТАНАА

Таны 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Мэдээлэл ирүүлэх тухай” 37 дугаар албан бичгийн дагуу Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төслийн мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

"ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ"
УДИРДЛАГА
САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН
2025.01.07 14:38

080001131

209

1. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл.

1.1. Эрх зүйн үндэслэл:

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам болон Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор 2008 оноос 2024 оны хооронд Үндэсний аюулгүй байдлын 2 зөвлөмж, Улсын Их Хурлын 5 тогтоол, Засгийн газрын 45 тогтоол, тэмдэглэл зэрэг эрх зүйн барим бичгүүд батлагдан гарсан байдаг.

"Монгол- Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр"-ийг шинэчлэн байгуулах тухай МУ-ын Зам, тээврийн яам, БНХАУ-ын төмөр замын газар хооронд харилцан ойлголцлын санамж бичгийг 2014 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан.

"Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т нэмэлт өөрчлөлт оруулах 2004.07.05-ны өдрийн саналыг хүлээн зөвшөөрч 2020 оны 09-р сарын 15-ны А/20-1008 дугаар ноот бичиг солилцож "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр" /2004он/-т Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтыг нэмж тусгасан.

Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-ын Гадаад хэргийн яам хооронд Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хилийн төмөр замын улсын хилийн шугам дайран өнгөрөх цэгийг тохирох тухай 2021.11.12-ны өдрийн 2021/54 дугаар ноот бичгийг хүлээн зөвшөөрсөн. Энэхүү ноот бичиг нь Хятадын ноот бичгийн хамт Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хилийн төмөр замын улсын хилийн шугам дайран өнгөрөх цэгийг тогтоосон тухай хэлэлцээр болно.

Монгол Улсын Их Хурлын 2023.07.07-ны өдрийн "1955 оны "Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр" болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай" 68 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2023.08.23-ны өдрийн "Монгол Улсын Их хурлын 2023 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 310 дугаар тогтоол тус тус батлагдаж, түүний үр дүнд Төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан.

1.2. Явцын мэдээлэл:

"Тавантолгой төмөр зам" ХХК болон "Хятадын зураг төслийн групп" компани нар 2023.05.26-ны өдөр гэрээ байгуулан Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн.

Монгол, Хятадын "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, магадлуулах ажил бүрэн дууссан.

"Тавантолгой төмөр зам" ХХК нь БНХАУ-ын "Чайна энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" ХК-тай Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийг байгуулахаар компанийн түвшинд тохиролцоод байна.

"Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн барьж хэлэлцүүлэн батлуулаад байна.

210

Харин БНАСАУ-ын хувьд түгжигдмэл байдлаасаа гарч өөрийн төмөр замын сүлжээгээ ашиглан олон улсын эдийн засгийн нээлттэй харилцаанд нэвтрэх боломж бүрдэх байсан.


Бүлгийн дүгнэлт

Онолын судалгааны бүлгийн хүрээнд дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Текст

211

1.3. Техникийн үзүүлэлт:



Үзүүлэлт	Өргөн цариг	Нарийн цариг
Замын зэрэглэл	I зэрэглэл	
Цариг	1520мм	1435мм
Нэг голын даралт	25тн	
Гол замын тоо	Нэг замтай	
Гол замын урт	8.7км	10.8км
Дэлгэмэл урт	12.1	20.5
Гүүрийн урт /9.5км/	Хос замтай гүүр 1.46км	
	Дан зам 4.3км	Дан зам 3.8км
Тооцоот хурд	100-120км/цаг	
Удирдах хэвгий	6‰	6‰ / 11‰
Татах төрөл	Дотоод шаталтат, цахилгаанжуулах боломжтой	
Зүтгүүрийн төрөл	АНУ-ын SD70Ace/Iw	HXN
Хүлээн авах явуулах замын ашигтай урт	1700м	1050м
Хориглолын төрөл	Өртөө хооронд хагас автомат	

2. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн ач холбогдол

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам нь өргөн царигаар жилд 30 сая тонн, нарийн царигаар 10 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай бөгөөд уг төсөл хэрэгжсэнээр 2030 оноос нүүрсний экспорт жил бүр 20 сая тонноор нэмэгдэж, эдийн засгийн өсөлт жил бүр 0.8 нэгж хувиар нэмэгдэх, ядуурлын түвшин буурч, нэг хүнд ногдох ДНБ-ийг 10000$-т хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6%-аас дээш түвшинд хадгалах, инфляцыг 5%-д барих зэрэг эдийн засгийн томоохон ач холбогдолтой болно.

Мөн Гашуунсухайт-Ганцмод боомт төмөр замаар холбогдох ажил эхэлснээр бусад боомтууд (Шивээхүрэн, Ханги, Бичигт)-ыг төмөр замаар холбох асуудал шийдэгдэнэ.

Түүнчлэн хоёр улсын тэргүүн нарын 2014 онд баталсан "Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал" хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Тус тунхаглал хэрэгжсэнээр Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, олон улс бүс нутгийн хамтын ажиллагаа, Эрдэс баялаг, Аж үйлдвэр, Дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжихээс гадна хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх стратегийн ач холбогдолтой.

Одоогоор Монгол Улсын нийт автотээврийн боомтын хүчин чадал нийт 85 сая.тн бөгөөд төмөр замын хилийн боомтууд (Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхтавч) ашиглалтад орсоноор 80 сая.тн-оор нэмэгдэж жилд экспортлох хүчин чадал 165 сая.тн-д хүртэл нэмэгдэнэ. Ингэснээр жил боомтын хил дамнасан төмөр замын тээврээр ойролцоогоор 4 тэрбум ам.долларын орлого олох боломж бүрдэнэ.

212

Иймээс Гашуунсухайт-Ганцмод боомтыг төмөр замаар холбох нь Монгол Улсын эдийн засаг болон байгаль орчинд эерэг нөлөөтэй бөгөөд 2 улсын харилцаа, түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх бусад мега төслүүдийг амжилттай болгоход чухал ач холбогдолтой юм.

3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын нүүрс тээвэрлэлтийн талаарх мэдээлэл.

"Тавантолгой төмөр зам" ХХК нь 2024 онд Тавантолгой-Гашуунсухайт-Тавантолгой чиглэлд төмөр замаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 1,747,611 тонн, "Эйр кэйтэринг" ХХК-ийн 4,256.1 тонн, нийт 1,751,867.43 тонн ачаа тээвэрлэсэн.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар ачаа тээвэрлүүлэхээр гэрээ байгуулсан 4 компани байгаа бөгөөд одоогоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ачааг төмөр замаар тээвэрлэж байна. Үүнд:

д/д	Байгууллагын нэр	Гэрээний дугаар	Ачааны хэмжээ	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Тайлбар
1	"Умард тээх" ХХК	ТэГ-2023/28-1	1 сая.тн	2023.12.19	2025.12.31	Одоогийн байдлаар ачаа тээвэрлүүлээгүй байна.
2	"Монголын дорнын сувд олон улсын чингэлэг тээвэр" ХХК	ТэГ-2024/03	1 сая.тн	2024.01.31	2025.01.30	Одоогийн байдлаар ачаа тээвэрлүүлээгүй байна.
3	"Эрдэнэс Тавантолгой" ХК	ТГ-2023/02 ТГ-2023/02+01	3.3 сая.тн	2023.02.15	2025.02.15	
4	"Тавантолгой" ХК	ТэГ-2024/17	0.5 сая.тн	2024.07.31	2025.07.31	Одоогийн байдлаар ачаа тээвэрлүүлээгүй байна.

Төмөр замаар ачаа тээвэрлэх журмын дагуу 2025 онд нийт 4 компани ачаа тээвэрлүүлэх хүсэлт, захиалга ирүүлсэн ба нийт захиалга нь 5.8 сая тонн ачаа болж байна! Үүнээс:

- "Эрдэнэс Тавантолгой" ХК 3,3 сая.тн,
- "Тавантолгой" ХК 0.5 сая.тн
- "Умард тээх" ХХК 1 сая.тн,
- "Монголын дорнын сувд олон улсын чингэлэг тээвэр" ХХК 1 сая.тн,

---oOo---